

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дүгээр  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Долдугаар бүлэг<sup>1</sup> бүлэг нэмсүгэй:

#### “ДОЛДУГААР БҮЛЭГ<sup>1</sup>”

#### БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

##### 75<sup>1</sup> дүгээр зүйл.Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

75<sup>1</sup>.1.Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс бага мөнгөн төлбөрийн үүргийг хангуулахаар гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг шүүх бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.

75<sup>1</sup>.2.Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар иргэний хэргийг хурдан шуурхай, хялбар, зардал багатай байдлаар шийдвэрлэнэ.

75<sup>1</sup>.3.Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэхэд энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмыг хэрэглэнэ.

75<sup>1</sup>.4.Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.

75<sup>1</sup>.5.Эрх зүйн нэг маргаанаас үүдэлтэй шаардлагыг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэх зорилгоор хэд хэдэн нэхэмжлэлээр хэсэгчлэн гаргахыг хориглоно.

75<sup>1</sup>.6.Гэр бүлийн харилцаанаас үүсэх бүх төрлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хэрэглэхгүй.

##### 75<sup>2</sup> дугаар зүйл.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэл гаргах

75<sup>2</sup>.1.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг Улсын дээд шүүхээс баталсан бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн загварын дагуу гаргана.

75<sup>2</sup>.2.Энэ хуулийн 75<sup>2</sup>.1-д заасан нэхэмжлэлийн загварт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэгчийн эрх, үүрэг, нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх, нотлох талаарх тайлбарыг тусгасан байна

### **75<sup>3</sup> дугаар зүйл.Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах**

75<sup>3</sup>.1.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн загварын дагуу нэхэмжлэл гаргаагүй бол шүүгч 5 хүртэлх хоногийн хугацаа тогтоон уг загварын дагуу гаргуулна.

75<sup>3</sup>.2.Нэхэмжлэгч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн загварын дагуу засварлаагүй бол уг нэхэмжлэлийг шүүгч хүлээн авахаас татгалзаж захирамж гаргана.

75<sup>3</sup>.3.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид нэхэмжлэгч гомдол гаргах эрхгүй.

### **75<sup>4</sup> дүгээр зүйл.Бага үнийн дүнтэй хэрэг үүсгэх**

75<sup>4</sup>.1.Шүүгч бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хүлээн авахад татгалзах үндэслэл байхгүй гэж үзвэл бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор бага үнийн дүнтэй иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75<sup>4</sup>.2.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэгчийн хүсэлтээр улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн, түүнийг багасгасан, хэсэгчлэн төлүүлэх болон хойшлуулах тухай асуудлыг шүүх шийдвэрлэсэн бол энэ талаар хэрэг үүсгэсэн захирамждаа тусгана.

### **75<sup>5</sup> дугаар зүйл.Тайлбар, нотлох баримт гаргах журам**

75<sup>5</sup>.1.Бага үнийн дүнтэй хэргийн оролцогч нэхэмжлэл гаргах, хариу тайлбар ирүүлэхдээ тайлбар, нотлох баримтаа бүрэн гаргаж, нотлох баримт бүрдүүлэх хүсэлтээ өгөх үүрэгтэй.

75<sup>5</sup>.2.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэргийн оролцогч энэ хуулийн 75<sup>5</sup>.1-д заасан үүргээ биелүүлэлгүй хугацаа хожимдуулж нэмэлт тайлбар, нотлох баримт гаргасан, цуглуулсан, эсхүл нотлох баримт бүрдүүлэх хүсэлт гаргасан бол шүүх хүлээн авахгүй.

### **75<sup>6</sup> дугаар зүйл.Шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлэх**

75<sup>6</sup>.1.Хэргийн оролцогчид шүүхийн мэдэгдэх хуудсыг утас, цахим шуудан, энэ хуулийн 77.2-т заасан хэлбэрээр хүргүүлнэ.

75<sup>6</sup>.2.Хэргийн оролцогчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ түргэн, шуурхай байх зарчмыг баримтлан энэ зүйлд заасан хэлбэрийг дараалал харгалзахгүйгээр сонгон хэрэглэнэ.

75<sup>6</sup>.3.Мэдэгдэх хуудсыг дараах байдлаар тогтоосон утасны дугаараар харилцан холбоо тогтоон мэдэгдэж болно.

75<sup>6</sup>.3.1.нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ тусгасан өөрийн болон төлөөлөгчийн утасны дугаар;

75<sup>6</sup>.3.2.нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ үнэн зөв тусгасан хариуцагч, эсхүл түүний төлөөлөгчийн утасны дугаар;

75<sup>6</sup>.3.3.шүүхэд хариуцагчийн мэдүүлсэн өөрийн болон төлөөлөгчийн утасны дугаар;

75<sup>6</sup>.3.4.талуудын хооронд байгуулсан гэрээнд тусгасан утасны дугаар.

75<sup>6</sup>.4.Мэдэгдэх хуудсыг утасны дугаараар харилцан холбоо тогтоон мэдэгдсэн бол шүүхийн ажилтан холбоо тогтоосон өдрийн он, сар, өдөр, утасны дугаар, харилцан ярилцсан агуулгын талаар тэмдэглэнэ.

75<sup>6</sup>.5.Мэдэгдэх хуудсыг дараах байдлаар тогтоосон цахим шуудангийн хаягаар илгээн мэдэгдэж болно.

75<sup>6</sup>.5.1.хэргийн оролцогч, түүний төлөөлөгчийн хувийн болон ажлын цахим шуудангийн хаяг;

75<sup>6</sup>.5.2.нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ тусгасан өөрийн болон төлөөлөгчийн цахим шуудангийн хаяг;

75<sup>6</sup>.5.3.нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ үнэн зөв тусгасан хариуцагч, эсхүл түүний төлөөлөгчийн цахим хаяг;

75<sup>6</sup>.5.4.шүүхэд хариуцагчийн мэдүүлсэн өөрийн болон төлөөлөгчийн цахим хаяг;

75<sup>6</sup>.5.5.талуудын хооронд байгуулсан гэрээнд тусгасан цахим шуудангийн хаяг;

75<sup>6</sup>.5.6.төрийн мэдээллийн нэгдсэн системд хадгалагдаж байгаа иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар бүхий цахим шуудангийн хаяг.

75<sup>6</sup>.6.Мэдэгдэх хуудсыг цахим шуудангийн хаягаар захидал илгээж мэдэгдсэн бол шүүхийн ажилтан захидал илгээсэн өдрийн он, сар, өдөр, явуулсан болон илгээсэн цахим шуудангийн хаяг, захидлын агуулгын талаар тэмдэглэнэ. Цахим шуудан илгээсэн баримтыг хуулбарлан тэмдэглэлд хавсаргана.

75<sup>6</sup>.7.Хэргийн оролцогчийн цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг хүргүүлснээс хойш 14 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

75<sup>6</sup>.8.Энэ хуулийн 77.2-т заасны дагуу шүүхийн мэдэгдэх хуудсыг хэргийн оролцогчид биечлэн хүргүүлж болно.

75<sup>6</sup>.9.Энэ хуулийн 75<sup>6</sup>.8-д заасан ажиллагааг хийсэн боловч хариуцагч тус хаягт оршин суудаггүй бол оршин суух албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

### **75<sup>7</sup> дугаар зүйл.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах**

75<sup>7</sup>.1.Бага үнийн дүнтэй хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг энэ хуулийн 75<sup>6</sup> дугаар зүйлд заасан хэлбэрээр гардуулна.

75<sup>7</sup>.2.Энэ хуулийн 75<sup>6</sup>.3-т заасан хэлбэрээр бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг гардуулах бол хариуцагчид шүүхэд өөрийн биеэр, эсхүл төлөөлөгч нь хүрэлцэн ирж, нэхэмжлэлийг гардан авахыг мэдэгдэнэ.

75<sup>7</sup>.3.Энэ хуулийн 75<sup>7</sup>.2-т зааснаас бусад тохиолдолд мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хувийг, хариу тайлбарын загварын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хүлээн авсанд тооцно.

### **75<sup>8</sup> дугаар зүйл.Хариуцагч хариу тайлбар ирүүлэх**

75<sup>8</sup>.1.Хариуцагч бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг гардан авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>8</sup>.2-т заасан хариу тайлбарын загварын дагуу шүүхэд хариу тайлбар болон нотлох баримтаа ирүүлэх үүрэгтэй.

75<sup>8</sup>.2.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална.

75<sup>8</sup>.3.Энэ хуулийн 75<sup>8</sup>.2-т заасан хариу тайлбарын загварт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцагчийн эрх, үүргийн талаар тайлбар тусгасан байна.

### **75<sup>9</sup> дүгээр зүйл.Хариу тайлбар ирүүлээгүй тохиолдолд үүсэх үр дагавар**

75<sup>9</sup>.1.Хариуцагч бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хүлээн авсан боловч хүндэтгэх үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 75<sup>8</sup>.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож, хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай захирамж гаргана.

75<sup>9</sup>.2.Энэ хуулийн 75<sup>9</sup>.1-д заасан үр дагаврыг нэхэмжлэл, мэдэгдэх хуудсыг хариуцагчид гардуулах үед мэдэгдэнэ.

75<sup>9</sup>.3.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч хүлээн зөвшөөрсөн бол энэ хуулийн 74.2-т заасан хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ.

### **75<sup>10</sup> дугаар зүйл.Хариуцагчийн хариу тайлбарыг тодруулах**

75<sup>10</sup>.1.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбарын загварын дагуу хариу тайлбар ирүүлээгүй бол шүүгч уг тайбарын шаардлага хангуулж ирүүлэх хугацааг 7 хүртэлх хоногоор тогтоон хариуцагчид даалгана.

75<sup>10</sup>.2.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбараа тодруулж ирүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг оногдуулж болно.

### **75<sup>11</sup> дүгээр зүйл.Хариу тайлбар ирүүлсэн тухай нэхэмжлэгчид мэдэгдэх**

75<sup>11</sup>.1.Хариуцагч нэхэмжлэлийн хариу тайлбар ирүүлсэн бол тэр даруй нэхэмжлэгчид мэдэгдэнэ.

### **75<sup>12</sup> дугаар зүйл.Сөрөг нэхэмжлэл**

75<sup>12</sup>.1.Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 75<sup>2</sup>.1-д заасан үнийн дүнгээс хэтрэхгүй шаардлага бүхий сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

75<sup>12</sup>.2.Сөрөг нэхэмжлэлийг зөвхөн хариу тайлбарын хамт гаргаж болно.

75<sup>12</sup>.3.Сөрөг нэхэмжлэлд үндсэн нэхэмжлэлтэй холбоотой ~~зөхицүүлэлт~~ энэ бүлэгт заасан журам нэгэн адил үйлчилнэ.

75<sup>12</sup>.4.Хэрэв сөрөг нэхэмжлэл нь 75<sup>1</sup>.1-д заасан үнийн дүнгээс их бол тухайн сөрөг нэхэмжлэлийг бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хамт ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлүүлэхээр энэ хуулийн 75<sup>13</sup>.2-т заасны дагуу шүүгч захирамж гаргаж шилжүүлнэ.

### **75<sup>13</sup> дугаар зүйл.Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих**

75<sup>13</sup>.1.Шүүх хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэхээр дараах тохиолдолд шилжүүлнэ:

75<sup>13</sup>.1.1.бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэл гаргахдаа энэ хуулийн 75<sup>1</sup>.1-д заасныг зөрчсөн;

75<sup>13</sup>.1.2.шүүх тухайн хэргийг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзсэн.

75<sup>13</sup>.2.Бага үнийн дүнтэй хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэхдээ шүүгч захирамж гаргана.

75<sup>13</sup>.3.Бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоосон тов ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчинтэй хэвээр байна.

#### **75<sup>14</sup> дүгээр зүйл.Бага үнийн дүнтэй хэргийн шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа**

75<sup>14</sup>.1.Хариуцагч бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбар ирүүлснээс хойш 14 хоногийн дотор шүүх хуралдааныг товлону.

75<sup>14</sup>.2.Шүүх хуралдаан товлөгдох хүртэл хэргийн оролцогч анх гаргасан бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, хариуцагч нэмж татах, гуравдагч этгээд оролцуулах, нэхэмжлэгч, хариуцагчийг солих, эрх залгамжлах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тогтоосон хугацаанд бүрдүүлэх бололцоогүй байсан нэмэлт тайлбар, нотлох баримт гаргаж болно.

75<sup>14</sup>.3.Хэргийн оролцогч шүүх хуралдаанаас өмнө энэ хуульд заасан эрхээ эдэлж, үүргээ бүрэн биелүүлж, бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцох үүрэгтэй.

75<sup>14</sup>.4.Хэргийн оролцогч өмгөөлөгч болон бусад этгээдээр бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлүүлэхийг хүсвэл шүүх хуралдаанаас өмнө уг эрхээ хэрэгжүүлэх бэлтгэл хангасан байна. Уг эрхээ хэрэгжүүлэх бэлтгэл хангаагүй нь шүүх хуралдаан хойшлох үндэслэл болохгүй.

75<sup>14</sup>.5.Шүүх хуралдаан товлөгдсоноос хойш шүүх хуралдаан болох хүртэл хэргийн оролцогч бага үнийн дүнтэй хэргийн материалтай танилцсан байна. Тухайн хэргийн материалтай танилцаагүй бол шүүх хуралдаан хойшлох үндэслэл болохгүй.

#### **75<sup>15</sup> дугаар зүйл.Нотлох баримт бүрдүүлэх**

75<sup>15</sup>.1.Бага үнийн дүнтэй хэргийн оролцогчийн шинжээчийн дүгнэлт гаргуулах болон гэрчийн мэдүүлэг авхуулах хүсэлтийг өөр нотлох баримтад үндэслэх боломжгүй бол хангаж шийдвэрлэнэ.

75<sup>15</sup>.2.Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлт болон нотлох баримт бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай бол шүүх бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг 30 хоногийн хугацаагаар сунгаж болно.

#### **75<sup>16</sup> дугаар зүйл.Бага үнийн дүнтэй хэргийн шүүх хуралдаан**

75<sup>16</sup>.1.Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг хуралдааныг хойшлуулахгүй бөгөөд нэг удаа шүүх хуралдааныг явуулна.

75<sup>16</sup>.2.Бага үнийн дүнтэй хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэнэ. Нэмэлт нотлох баримт хэрэгт авах зорилгоор шүүх хуралдааныг хойшлуулахгүй.

75<sup>16</sup>.3.Шүүх шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг нэг удаа 14 хүртэлх хоногоор хойшлуулж болно.

### **75<sup>17</sup> дугаар зүйл.Шүүх хуралдааны тэмдэглэл**

75<sup>17</sup>.1.Шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогч бичгээр гаргах хүсэлт гаргаагүй бол аудио бичлэгээр үлдээн хадгална.

### **75<sup>18</sup> дугаар зүйл.Хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр**

75<sup>18</sup>.1.Шүүхээс бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэж шийдвэр гаргана.

75<sup>18</sup>.2.Энэ хуулийн 75<sup>18</sup>.1-д заасан шийдвэрийн боловсруулах аргачлалыг Монгол Улсын дээд шүүхээс батална.

75<sup>18</sup>.3.Бага үнийн дүнтэй хэргийн шүүхийн шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ хуулийн 75<sup>6</sup> дугаар зүйлд заасан хэлбэрээр хэргийн зохигч, төлөөлөгчид гардуулна.

### **75<sup>19</sup> дүгээр зүйл.Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрөх**

75<sup>19</sup>.1.Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75<sup>18</sup>.3-т зааснаар гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

75<sup>19</sup>.2.Шүүхийн давж заалдах журмаар гомдол гаргасан бага үнийн дүнтэй хэргийг давж заалдах шатны шүүх хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

75<sup>19</sup>.3.Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн үндэслэлээр хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаахаас бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх тухайн хэргийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

75<sup>19</sup>.4.Бага үнийн дүнтэй хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол анхан шатны шүүх хэргийг энэ бүлэгт заасан журмаар шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх  
тухай хуульд нэмэлт оруулах  
тухай төслийн талаар

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 онд батлагдсан бөгөөд тус хуулийн 12 дугаар бүлэгт “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”, 13 дугаар бүлэгт “Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа”, 14 дүгээр бүлэгт “Гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа”-г тус тус зохицуулснаас өөрөөр хэргийн онцлогийг харгалзан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ялгамжтай зохицуулалт бий болгосон зохицуулалт байхгүй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаагаар тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гаргасан 2022 оны мэдээнд дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд хэргийг хэлэлцэхээр нийт 39,691 шүүх хуралдаан зарласнаас 21,619 буюу 54,4 хувь нь хойшлогдсон байна. Хүний нөөц болон техникийн нөхцөл байдлаас хамаарч нарийвчилсан судалгаа гаргахад хүндрэлтэй боловч анхан шатны шүүх дунджаар нэг хэргийг 30-120 хоног, зарим төрлийн хэргүүд түүнээс дээш 1-3 жилийн хугацаанд тус тус хянан шийдвэрлэгдэж байгаа бол хяналтын шатны шүүхэд 2022 оны байдлаар нийт 1782 хэрэг хянагдаж байна. 2020 оноос хойш хэрэг 1335, 2015-2019 онд 441, 2011-2014 онд 6 хэрэг хянагдаж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралтай байдал нь нэг талаас хэргийн оролцогчийн хаяг тодорхой бус, шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг буюу нэг шүүгч, шүүгчийн туслахад ногдож байгаа хэргийн тоо хэт их, шүүх хуралдааны танхим, иргэдэд үйлчлэх нөхцөл бололцоо, орчин шаардлага хангахгүй зэрэг төрөөс шалтгаалах хүчин зүйлсүүд нөлөөлж байгаа ч нөгөө талаас бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэхэд тохирсон хянан шийдвэрлэх ажиллагаа, хэргийн удирдлагын эрх зүйн орчин бий болоогүйгээс үүдэлтэй байна.

Түүнчлэн Нээлттэй нийгэм форумын 2022 онд гаргасан “Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн практикт хийсэн дүн шинжилгээ” сэдэвт судалгааны бүтээл <https://forum.mn/post/122184/>-д бага үнийн дүнг 13,000,000 төгрөгөөр тооцсон байх бөгөөд 2019 онд 43,397 иргэний хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 20,624 буюу бараг 48 хувь нь иргэний эрх зүйн маргаан байсан бол үүнээс бага үнийн дүнтэй хэрэг 5,710 байсан нь улсын хэмжээний дүнд 13 хувийг эзэлж байна. Түүнчлэн бага үнийн дүнтэй иргэний хэрэг 2018 онд 5,411 шийдвэрлэгдсэн бол 2019 онд 5,710 болж 299-өөр буюу 5.3 хувиар өсжээ.

Нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 онд хянан шийдвэрлэгдсэн нийт 34,083 хэрэг маргааны 8200 хэрэг буюу 24.06 хувь нь 11,000,000 төгрөгөөс бага үнийн дүнтэй хэргүүд байх ба эдгээр хэргээс түүвэрлэн шийдвэрлэсэн хугацааг судлан үзэхэд хэргийг дунджаар 109.4 хоногт хянан шийдвэрлэсэн байна. Нийт шийдвэрлэсэн 11,000,000 төгрөгөөс бага үнийн дүнтэй хэргийн 3.66 хувь нь давж заалдах журмаар гомдол гаргасан бол 1.22 хувь нь хяналтын шатны шүүхэд ханджээ.



Нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс ажлын ачаалал харьцангуй бага байдаг орон нутгийн тухайлбал, түүвэрлэн авсан Баян-Өлгий, Өмнөговь, Хэнтий, Говь-Алтай аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 онд шийдвэрлэсэн хэргийн мэдээнээс үзэхэд дундажаар нийт шийдвэрлэсэн хэргийн 12-15 орчим хувь нь 11,000,000 төгрөг хүртэлх үнийн дүнтэй хэргүүд байх бөгөөд эдгээр хэргийн хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа 37-75 хоног байна.

Хэргийн онцлог, эрх зүйн харилцааны төдийлөн төвөгтэй бус байдал нь хэргийн оролцогчид тухайн маргааныг аль болох богино хугацаанд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энгийн, ойлгомжтой журмаар шийдвэрлүүлэх хүлээлтийг үүсгэдэг. Энэ ч утгаар шүүх хуралдаан олон удаа хойшлох, нотлох баримт бүрдүүлэх ердийн ажиллагааны хүндрүүлсэн хэлбэрүүд нь хэргийн оролцогчийн бухимдлыг төрүүлж, шүүхэд итгэх итгэлийг бууруулах сөрөг үр дагавартай байна.

Монгол Улсын шүүх эрх мэдлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор Нээлттэй нийгмийн форумаас хийсэн Шүүхийн индекс 2021 (<http://judindex.forum.mn/>) судалгааны ажилд 6 үндсэн, 42 дэд хэмжигдэхүүнийг ашиглажээ. Үүнээс “Шүүх хэрэг, маргааныг боломжийн хугацаанд шийдвэрлэдэг эсэх” гэсэн асуулгыг олон нийт 24.27 хувиар үнэлсэн нь тус судалгааны ажлын бүх шалгуур үзүүлэлтээс хамгийн бага оноо авсан шалгуур үзүүлэлт болсон байна. Энэ нь шүүхээр үйлчлүүлэгчдийн үнэмлэхүй олонхи нь шүүхийн процесс ажиллагааны удаашралтай байдалд илтэд сэтгэл хангалуун бус байгааг илэрхийлж байна.

Иймд харьцангуй тодорхой эрх зүйн маргаанаас үүдэлтэй, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн шаардлага бүхий иргэний хэргийн онцлогт тохирсон нотлох баримт бүрдүүлэх, үнэлэх ажиллагааг хялбаршуулж, энгийн болгосон хянан шийдвэрлэх хугацааг богиносгох замаар шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны тусгайлсан төрлийг бий болгох нь зүйтэй байна.

Бусад улсын жишгийг авч үзвэл бага үнийн дүнтэй маргааныг хурдан шуурхай шийдвэрлэх тусгай хэрэг хянан шийдвэрлэх процессыг бий болгосон байх явдал нийтлэг бөгөөд ихэвчлэн мөнгөн төлбөрийн үүргийг шаардаж байгаа нэхэмжлэлд тодорхой үнийн дүнгийн дээд хязгаар тавигддаг.

№	Улс, орнууд	Бага үнийн дүнтэй хэргийн шалгуур
1	Европын холбоо	5,000 евро хүртэл <sup>1</sup>
2	Англи	10,000 фунтээс хэтрэхгүй байх <sup>2</sup>
3	Япон	1,400,000 иен хүртэл <sup>3</sup>

<sup>1</sup> Сүүлд нэвтэрсэн:2023.09.15. [https://europa.eu/youreurope/business/dealing-with-customers/solving-disputes/european-small-claims-procedure/index\\_en.htm](https://europa.eu/youreurope/business/dealing-with-customers/solving-disputes/european-small-claims-procedure/index_en.htm)

<sup>2</sup> Сүүлд нэвтэрсэн:2023.09.15. <https://www.citizensadvice.org.uk/law-and-courts/legal-system/small-claims/making-a-small-claim/>

<sup>3</sup> Сүүлд нэвтэрсэн:2023.09.15. [https://www.courts.go.jp/english/judicial\\_sys/qa\\_on\\_Summary\\_Court\\_Procedure/index.html](https://www.courts.go.jp/english/judicial_sys/qa_on_Summary_Court_Procedure/index.html)

4	Солонгос	30,000,000 воноос хэтрэхгүй байх <sup>4</sup>
---	----------	---

Тухайлбал, Солонгосыг авч үзвэл бага үнийн дүнтэй хэргийн хүрээг 30,000,000 воноос хэтрэхгүй байхаар тодорхойлсон бөгөөд үүнийг төгрөг рүү шилжүүлбэл 75 сая орчим төгрөг болон Япон Улсын хувьд 1 400 000 иен буюу 13 орчим сая төгрөг байна.

### **Бага үнийн дүнтэй хэргийн тодрхойлолт**

Хуулийн төсөлд бага үнийн дүнтэй хэргийн хүрээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс бага мөнгөн төлбөрийн үүргийг хангуулахаар гаргасан нэхэмжлэл байхаар зохицууллаа.

Бусад улсын зохицуулалтыг авч үзвэл тогтмол үнийн дүн заах нь нийтлэг боловч манай улсын хувьд инфляцын хэлбэлзэл өндөр тул хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жишиг болгох нь нийгмийн хэрэгцээнд нийцсэн уян хатан байдлыг бий болгох давуу талтай юм.


Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэлийн үнийн дүнгийн дээд хязгаар нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байхаар төсөлд тусгав. Ингэснээр одоогийн нэг сарын хөдөлмөрийн хөлс (550 000 төгрөг)-ний доод хэмжээгээр тооцвол, нэхэмжлэлийн үнийн дүнгийн дээд хязгаар нь 11 сая төгрөг болно.

Бага үнийн дүнтэй хэргийн бусад хэргээс ялгарах онцлог нь дийлэнх тохиолдолд хэргийн үйл баримт тодорхой, маргаан багатай байдаг шинжийг агуулдаг. Энэхүү шинж чанар дээр тулгуурлан бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь иргэний хэргийг хурдан шуурхай, хялбар, зардал багатай байдлаар шийдвэрлэх боломжтой байна. Иймээс манай улсад гарч буй иргэний хэргийн дундаас үйл баримт тодорхой, маргаан багатай байдаг шинжийг агуулсан хэргийг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны объект болгох боломжтой байна.

Шүүхийн практикт мөнгөн төлбөрийн үүргийг хангуулах нэхэмжлэл ихэнх хувийг эзлэх бөгөөд тэр дундаа зээлийн гэрээ, худалдах худалдан авах гэрээ, эд хөрөнгө хөлслөх, түрээсийн гэрээний маргаан түлхүү байр суурийг эзэлдэг.


<sup>4</sup> Сүүлд нэвтэрсэн: 2023.09.15. [https://jifi.scourt.go.kr/foreigner/en/html/proceedings/civil/small\\_claims\\_cases.html](https://jifi.scourt.go.kr/foreigner/en/html/proceedings/civil/small_claims_cases.html)

Тухайлбал, 2018 он болон 2019 оны иргэд хоорондын зээлийн маргааны үнийн дүнг дараах судалгааны графикаас<sup>5</sup> харж болно.



Энэхүү судалгаанаас авч үзвэл иргэд хоорондын зээлийн гэрээний маргааны 80 орчим хувь нь 13 сая төгрөг хүртлэх үнийн дүнтэй байна.

Цаашлаад тус судалгаанаас уг төрлийн маргааныг шүүхээс хянан шийдвэрлэсэн байдлыг дараах судалгааны графикаас<sup>6</sup> харж болно.



Эндээс авч үзвэл нийт хэргийн 70 гаруй хувь нь маргаан багатай буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар болон мөн хуулийн 106 дугаар зүйлийн 106.5 дахь хэсэгт заасан шүүх хуралдааны явцад талууд тохиролцоонд хүрэх байдлаар маргаанаа шийдвэрлэсэн байна.

Иймээс бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэлийн үнийн дүнгийн дээд хязгаар нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байхаар төсөлд тусгасан.

<sup>5</sup> Б.Хонгорзул нар “Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик” 2022 он, Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа, Цуврал 7, 27 дахь тал

<sup>6</sup> Б.Хонгорзул нар “Бага үнийн дүнтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй шүүхийн практик” 2022 он, Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа, Цуврал 7, 28 дэх тал

Нөгөө талаас нэхэмжлэлийн үнийн дүн нь 11 сая төгрөг хүртэлх хэрэг дунд нарийн ээдрээ төвөгтэй, маргаан ихтэй буюу бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахад зохимжгүй хэрэг байж болно. Энэ тохиолдолд шүүх тухайн хэргийг бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзвэл ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа руу шилжүүлэхээр төсөлд тусгасан.

### **Бага үнийн дүнтэй хэргийг хялбар байдлаар шийдвэрлэх**

Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг Улсын дээд шүүхээс баталсан бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн загварын дагуу гаргахаар төсөлд заасан. Мөн бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбарын загварыг Улсын дээд шүүх батлах бөгөөд уг загварын дагуу шүүхэд хариу тайлбар ирүүлэхээр заасан.

Улсын дээд шүүхээс гаргасан загварыг бөглөх байдлаар нэхэмжлэл, хариу тайлбар гаргах нь хэргийн оролцогчийн шүүхэд мэдүүлэх үйл явцыг хялбар болгохоос гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхойгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлнэ. Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогч шаардлага, татгалзлаа анхнаасаа зөв тодорхойлох, хэргийн үйл баримтыг бүрэн, тодорхой гаргах нөхцөл бүрдэнэ.

Мөн Улсын дээд шүүхээс гаргасан загвар нь хэргийн оролцогчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх, үүргийг тайлбарласан байх бөгөөд энэ нь хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарлах шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг хөнгөвчлөх болно.

Хэргийн оролцогчид шүүхийн мэдэгдэх хуудсыг утас, цахим шуудан зэрэг иргэдийн өдөр тутамдаа байнга хэрэглэдэг арга хэрэгслээр хүргүүлэх боломжийг тодорхой болгож тусгалаа.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогч бичгээр гаргах хүсэлт гаргаагүй бол аудио бичлэгээр үлдээн хадгалж үлдээхээр зохицуулсан.

Түүнчлэн, шүүхээс бага үнийн дүнтэй хэргийн шийдвэрийн дэлгэрэнгүй бүтэц, боловсруулах аргачлалыг Монгол Улсын дээд шүүхээс батлахаар заасан.

### **Бага үнийн дүнтэй хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх**

Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад хугацаа богино байхаар хуульчилсан. Ялгааг дараах хүснэгтээр харьцуулан харуулав.

<b>№</b>	<b>Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа</b>	<b>Бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа</b>
<b>1</b>	§66.1.Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.	§75 <sup>4</sup> .1.Шүүгч бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хүлээн авахад татгалзах үндэслэл байхгүй гэж үзвэл бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор

		бага үнийн дүнтэй иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.
2	§72.1.Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш хариуцагчид нэхэмжлэлийг нийслэлд 7 хоногийн, орон нутагт 14 хоногийн дотор тус тус гардуулна.	§75 <sup>7</sup> .1.Бага үнийн дүнтэй хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг энэ хуулийн 75 <sup>6</sup> дугаар зүйлд заасан хэлбэрээр гардуулна.
3	§72.2.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй.	§75 <sup>8</sup> .1.Хариуцагч бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг гардан авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ хуулийн 75 <sup>8</sup> .2-т заасан хариу тайлбарын загварын дагуу шүүхэд хариу тайлбар болон нотлох баримтаа ирүүлэх үүрэгтэй.
4	§119.4.Шүүх хуралдаанд оролцсон тал энэ хуулийн 119.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж шийдвэрийг өөрөө гардан авна.	§75 <sup>19</sup> .3.Бага үнийн дүнтэй хэргийн шүүхийн шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ хуулийн 75 <sup>6</sup> дугаар зүйлд заасан хэлбэрээр хэргийн зохигч, төлөөлөгчид гардуулна.
5	§120.2.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах гомдол гаргаж болно.	§75 <sup>20</sup> .1.Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 75 <sup>19</sup> .3-т зааснаар гардуулснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.
6	§166.2.Давж заалдах гомдол гарсан хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.	§75 <sup>20</sup> .2.Шүүхийн давж заалдах журмаар гомдол гаргасан бага үнийн дүнтэй хэргийг давж заалдах шатны шүүх хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

Бага үнийн дүнтэй хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх үүднээс ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар хуульд заасан хугацааг богиносгож зохицуулсан.

Мөн хариу тайлбар ирүүлснээс хойш 14 хоногийн дотор шүүх хуралдааныг товлох талаар заавал баримтлах хугацааг зааж өгсөн. Энэ нь хэзээ шүүх хуралдаан товлох талаар тодорхойгүй байдал үүсгэдэг явдлыг арилгах бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай явуулах гол механизм болно гэж үзлээ.

Түүнчлэн шүүх шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг нэг удаа 14 хүртэлх хоногоор хойшлуулж болохоор зохицуулсан. Энэ нь шүүгч хэргийн нөхцөл байдалд тохируулан уян хатан байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах нөхцөлийг бүрдүүллээ.

Ийнхүү бага үнийн дүнтэй хэргийг хурдан шуурхай шийдвэрлэхийн тулд тодорхой хугацаа тогтоосноос гадна, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатуудыг тодорхой тусгасан.

Тухайлбал, хэргийн оролцогчийн цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг хүргүүлснээс хойш 14 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцохоор заасан. Улмаар хариуцагч бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийг хүлээн авсан боловч хүндэтгэх үзэх шалтгаангүйгээр хариу тайлбар ирүүлэх үүргээ биелүүлээгүй нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцохоор тусгасан. Мөн шүүх хуралдаан товлогдох хүртэл хэргийн оролцогч шүүх хуралдаанд оролцох бэлтгэлээ хангах талаар хуульчилсан бөгөөд ялангуяа өмгөөлөгч болон бусад этгээдээр бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлүүлэх, хэргийн материалтай танилцах зэрэг бэлтгэл ажиллагааг тус үе шатанд хангасан байхаар заасан.

### **Бага үнийн дүнтэй хэргийг зардал багатай шийдвэрлэх**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хурдан шуурхай байх, хялбар байх нь зардал багатай байхтай шууд хамааралтай болно. Мөн бага үнийн дүнтэй хэргийн оролцогчийн шинжээчийн дүгнэлт гаргуулах болон гэрчийн мэдүүлэг авхуулах хүсэлтийг өөр нотлох баримтад үндэслэх боломжгүй бол хангаж шийдвэрлэхээр зохицуулсан. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, зардал нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Түүнчлэн бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулахгүй нэг удаагийн шүүх хуралдаанаар шийдвэрлэхээр төсөлд тусгасан. Шүүх хуралдаан удаа дараа хойшлох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж, зардлыг нэмэгдүүлдэг. Тиймээс шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг тодорхой үр дагавартай хуульчлах нь шүүх хуралдаан хойшлох эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр тусгалаа.

## **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

